

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
<i>Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.5.1.7, Алсын хараа -2050 урт хугацааны хөгжлийн бодлого 6.3.9, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.5.1.2, 5.1.11, БОАЖЯ-ны стратегийн зорилт 1.3, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.3.2.3.</i>							
1	Арга хэмжээ 1.1. "Хэрлэн тооно" төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай усны нөөцийн дүгнэлтийг гаргаж өгөх	-	Дүгнэлтийн тоо	-	-	МУ-ын ЗГ-ын 2025 оны 05-р сарын 27-ны өдрийн 223 дугаар тушаалаар Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд судагаа, шинжилгээг хийх, үр ашигтай төслүүдийг эхлүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, салбар дундын уялдааг хангах үүрэг бүхий "Говийг усжуулах судалгааны нэгж"-ийг байгуулсан. "Хэрлэн тооно" төслийн ТЭЗҮ-ийн тодотголыг Монхидроконштракшн ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2026 оны 03-р сард уг ажлыг хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Иймд манай газраар ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлээгүй.	100%
2	Арга хэмжээ 1.1. Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн зохион байгуулах		Тайлан	2024.05.20-нд гэрээ байгуулсан.	Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн зохион байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан байна.	"Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийг хэрэгжүүлэх" ажлыг 2025 оны 3 сард ажл "Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийг хэрэгжүүлэх" ажлыг 2025 оны 3 сард ажлыг эхлүүлсэн. Хийгдэж буй ажлын явцын талаар фото зураг ирүүлсэн. СГЗ 1 удаа очиж хяналт тавин ажилласан.	100%
3	Арга хэмжээ 1.2. "Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт орших	197.2 сая.төг Улсын төсөв	Хяналтын тоо	-	Ажлын гүйцэтгэлд 1-ээс доошгүй удаа хяналт тавин ажилласан байна	Захиалагчийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлж буй Говь-Алтай аймгийн Байгаль орчны газар, байгаль хамгаалагчид усны барилга байгууламжийн гүйцэтгэлд 2 удаа	100%

	Эрэн нуурыг сэргээх" төслийн гүйцэтгэлд хяналт тавих					хяналт хийсэн. Хяналтаар "Эрэн нуур" жуулчны баазын орчим халиа маш ихээр үүссэн, толгойн барилгын далан зарим газраа сэтэрсэн, далан нурсан зэрэг асуудлууд гарсан байна. "Эрэн нуурыг сэргээх" ажлын урсац тохируулах, халиах барилгын туршилт тохируулгын ажил 06 дугаар сарын 15-аас эхлэхээр "Усны эрчим" ХХК бэлтгэл ажлыг хийн ажиллаж байна.	
4	Арга хэмжээ 1.3. Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд баруун бүсийн гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах төсөл хэрэгжүүлнэ.	6589.6 сая.төг Улсын төсөв	Хөв цөөрмийн тоо	-	Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд, ТЭЗҮ, Зураг төсөл концепци албажуулж, 42 хөв цөөрөм байгуулах төслийн тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.	Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймгийн гадаргын ус хомсдолтой 38 суманд байгуулах 42 хөв цөөрмийн ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ТХААГ-т зарласан. 2025 оны 05 сарын 30-ны өдрийн байдлаар Ховд аймгийн Дөргөн суманд байгуулах хөвийн ажлыг гүйцэтгүүлэхээр "ССТ ОД" ХХК, мөн Дарви сумын Хөвхөрийн голыг түшиглэн байгуулах Булган нуур хэмээх хөвийг байгуулахаар "Эко буянт" ХХК-тай Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах ажил гүйцэтгэх гэрээг 2025.05.09-нд байгуулсан. Завхан аймгийн Сонгино сумын "Тал булаг"-ийн хөв цөөрөм, мөн Шилүүстэй сумын нутагт бага оврын хөв цөөрөм байгуулах ажлыг гүйцэтгүүлэхээр "Манант Оргил" ХХК-тай 2025.05.30-нд тус тус гэрээ байгуулсан. Үлдсэн 7 багц ажил нь оролцогчгүй байсан тул 2025.05.27-нд тендерийг дахин зарласан. Ажлын гүйцэтгэл 100%-тай байна.	100%
ХОЁРДУГААР ХЭСЭГ. УСНЫ НӨӨЦ, ТҮҮНИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ УСНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ							
<i>Усны тухай хуулийн 28.4, 28.7, 16¹.4.9, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.5.2.1, 2.5.6.4</i>							
5	Арга хэмжээ 2.1. Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх	Төсөв шаардахгүй	Дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн	2024 онд усаар хангагч 19	Усаар хангагч байгууллагуудаас дүгнэлт гаргахаар	Усаар хангагч байгууллагын ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар нийт 22 хүсэлт ирснээс шийдвэрлэгдсэн-19, боловсруулж байгаа-1,	100%

	үүсвэрийн ус хангагч байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гаргах		хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлтийг 100 хувь гаргасан	ирүүлсэн хүсэлтийн 90-өөс доогүй хувьд шийдвэрлэж, ус ашиглалтын мэдээллийг тайлагнасан байна.	засварт буцаасан-2 буюу нийт хүсэлтийн 96.4 хувийн гүйцэтгэлтэй байна.	
6	Арга хэмжээ 2.3. Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргах	Төсөв шаардахгүй	Дүгнэлтийн тоо	2024 онд 265 аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг 100 хувь гаргасан	Дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу ус ашиглуулах дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нь 90-өөс доогүй хувьд шийдвэрлэж, ус ашиглалтын мэдээллийг хагас жилийн байдлаар нэгтгэн гаргасан байна.	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар www.ewater.mn хаягаар давхардсан тоогоор 279, цаасаар 6 хүсэлт ирсэнээс 172 хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, боловсруулж байгаа-23, засварт буцаасан-24, давхардаж ирсэн болон усны хэрэглээ буруу сонгон ирүүлсэн устгах шаардлагатай 40 хүсэлт байна. Эхний хагас жилийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна. үгнэлт гаргуулсны үйлчилгээний хөлс-753,297,377.66 төг төвлөрүүлсэн байна. Мэдээллийг салбараар, аймаг, Сав газраар гарган нэгтгэсэн.	100%
7	Арга хэмжээ 2.4. Улсын хэмжээнд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавих	Төсөв шаардахгүй	Хяналтын тоо	2024 онд 29 сав газрын нийт 177 ус ашиглуулах дүгнэлт, 205 гэрээ, 194 зөвшөөрлийн мэдээллийг 3 удаа авч хянасан	Эхний хагас жилийн байдлаар гаргасан дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний цахим бүртгэлийг нэгтгэж, шийдвэрлэлтийн байдалд 2-оос доошгүй удаа хяналт тавьсан байна.	Усны мэдээллийн нэгдсэн системээр ирүүлсэн хүсэлтүүдийг судлан боловсруулаад усны газрын дүгнэлтийн хуралд оруулсан. Дүгнэлтийн хурлаар гэрээ, өмнөх оны дүгнэлт, зөвшөөрөл хяналтыг тавьж танилцуулсан. Эрчим хүчний зохицуулах хорооны Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нийт 53 ААНБ байдгаас хүн амын ус хангамжаар үйл ажиллагаа явуулдаг 40 ААНБ байна. Эдгээр байгууллагууд руу ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллах тухай 2025.04.22-ны өдрийн 01/217 дугаартай бичгээр чиглэл өгч ажилласан. 29 Сав газрын захиргаад болон 21 аймаг, нийслэлийн БОГ-даас 2025 оны эхний хагас жилд гаргасан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавин, зөвлөгөө өгч ажилласан. СГЗ-ын ногдуулсан усны хэмжээ: 1,145,500.0 м ³ /жил, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр:	100%

						305.7 сая төгрөг, БОГ-ын ногдуулсан усны хэмжээ: 351,172.36 м³/жил, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр: 50.8 сая.төгрөг.	
8	Арга хэмжээ 2.5. Цас, бороо, үерийн усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах байдлаар мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан усны төлбөрөөс чөлөөлөх урамшууллын механизмыг хэрэгжүүлэх	Төсөв шаардахгүй	Гүйцэтгэлийн хувь	-	Цас, бороо, үерийн усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах байдлаар мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан усны төлбөрөөс чөлөөлдөг талаар мэдээлэл хийж, усны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна	Улсын хэмжээнд 2020-2024 онд цас, бороо, үерийн ус хуримтлуулах зориулалттай 46 ширхэг хөв цөөрөм байгуулсан. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын дагуу тухайн хөв цөөрөмд хуримтлагдсан уснаас ахуйн зориулалтаар мал аж ахуй, газар тариаланд ашигласан усыг төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. Уул уурхайн технологи, зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах усыг шүүрэл болон нууранд хуримтлагдсан уснаас эргүүлэн ашиглаж буй тохиолдолд усны төлбөрийг 100% чөлөөлж тооцож байна.	100%
9	Арга хэмжээ 2.6. Хоногт 100 шоометрээс их ус ашиглагчаас усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	Төсөв шаардахгүй	Хуулийн хэрэгжилт хангуулсан хувь	-	Эхний 5 сарын байдлаар ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн 30-аас доошгүй хувийг ус ашиглалтын менежертэй болгосон байна	Усны мэдээллийн нэгдсэн системээр 172 дүгнэлт баталгаажуулан хүргүүлэхдээ Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах тухай хуулийн заалтыг ус ашиглуулах дүгнэлтийн онцгой нөхцөлд хэсэгт тусгасан. Эхний хагас жилийн байдлаар ус ашиглалтын менежерийн албан тушаалд томилсон тухай тушаалуудтай танилцахаар баталгаажуулсан 172 дүгнэлт гаргуулсан иргэн, ААНБ-д утсаар мэдэгдсэн. Нийт ус ашиглагчийн 52 хувь нь усны менежертэй болсон.	100%
10	Арга хэмжээ 2.7. Ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулах систем бий болгох хүрээнд ус ашиглагчдыг бүртгэлжүүлэн усны хэрэглээг тоолууржуулах		Нийт ус ашиглагчдаас тоолууржуулалтад хамрагдсан хувь	5	Нийт ус ашиглагчдаас 8 хувийг тоолууржуулалтад хамруулсан байна.	Хоногт 100 шоометрээс их ус ашиглагч 172 аж ахуйн нэгж байгууллагад ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, дүгнэлтийн тавигдах шаардлагад Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах, усны нөөцийг зохистой ашиглах, тоолууржуулахыг даалгаж, биелэлтийг хангах талаар зөвлөмж өгч, аргазүйгээр хангаж ажилласан. Ус ашиглагч аж ахуйн	100%

						нэгжүүдийн 50-иас багагүй хувь нь ус авах цэг, шугам хоолой бүрийг тоолууржуулсан. Усаар хангагч 22 байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийн "Онцгой нөхцөл болон тавигдах шаардлагад" Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах, усны алдагдалыг бууруулах талаар тусгаж байна. Мөн дүгнэлт гаргуулахаар материал бүрэн ирүүлсэн хүсэлтүүдийг судалж Усны газрын дүгнэлтийн хурлаар танилцуулсан. Нийт ус ашиглагчдаас 15 хувийг тоолууржуулалтад хамруулсан.	
11	Арга хэмжээ 2.8. Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төслүүдэд дүгнэлт гаргах		Гүйцэтгэл ийн хувь	Усны барилга байгууламж ийн зураг төсөлд 18 дүгнэлт гаргуулах хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн	Ирүүлсэн хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж 90-өөс доогүй хувьд дүгнэлт гаргасан байна.	"Хөх металл проперти" ХХК-ийн Хөв цөөрмийн зураг төсөл, "Эрч булаг лайн" ХХК-ийн шүүрлийн ус шавхан зайлуулах шугам хоолойн угсралтын зураг төсөл, "Армеко майнинг" ХХК, "Эрдэнэс критикал минералс" ХХК, "Хос Хас" ХХК-ын хаягдлын сангийн зураг төсөлд холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд дүгнэлт гаргасан. Нийт 5 хүсэлт ирснийг шийдвэрлэсэн. Гүйцэтгэл 100%	100%
ГУРАВ ДУГААР ХЭСЭГ. ОЛОН НИЙТИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЖ, УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖУУДЫГ СУРТАЛЧИЛАХ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭН ХӨРШ ОРНУУДАЙ БАЙГУУЛСАН "ХИЛИЙН УСЫГ ХАМГААЛАХ, АШИГЛАХ ТУХАЙ" ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ.							
12	Арга хэмжээ 3.1. Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах	Төсөв шаардахгүй	"Цэнхэр алт" үндэсний чуулган зохион байгуулах. - Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил	2024 онд "Цэнхэр тууз" аяныг зохион байгуулсан	Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • Сав шим" нэгдлийн уран бүтээлчид хоёр жилийн турш Туул голын олон арван цутгал, гол горхи, нуур тогтоол бүхий айсаваар 7000 гаруй км аялж, уул хайрхан ус булаг бүрийг нь зурагласан. Тус зургуудыг хэлтсийн мэргэжлтнүүдийн хамт хэвэлж, жааз өөрсдөө гараар бэлдэн Усны газрын байранд "Судрын долгион Туул" фото зургийн үзэсгэлэнг гаргасан. • Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан "Цэнхэр 	100%

			зохион байгуулах			алт” үндэсний хоёрдугаар чуулганыг зохион байгуулах ажлын хэсэгт оролцож оролцогчдын мандат тараах, мандатны нэрс бичих, хүргэж өгөх, хурлын өдөр хүлээн авах зэрэг зохион байгуулалтын ажилд оролцсон. • Мөн төлөвлөгөөнд тусгагдсан илтгэгч нартай холбогдож, илтгэл, танилцуулгыг нэгтгэх болон бусад хариуцсан ажлын бэлтгэлийг бүрэн хангаж “Усны нөөцийн нэгдсэн менежмент, талуудын оролцоо” форумд оролцсон.	
13	Арга хэмжээ 3.2. Агентлагийн үйл ажиллагаанд хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийт, иргэдэд ил тод, нээлттэй байлгах, мэдээлэл авах эрх тэгш боломжоор хангах	Төсөв шаардахгүй	Үнэлгээний хувь	shilen.gov.mn системийн хэрэгжилт 20 хувьтай	Цахим сайтуудад оруулах мэдээллийг тухай бүр бүрэн оруулж shilen.gov.mn системийн үнэлгээг 50 хувьд хүргэх	Монгол орны ус ашиглалтын мэдээллийг илтгэл, хүснэгт, вордоор гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж, мэдээлэлд нэгтгэн оруулсан. Үүнд: - Уул уурхайн хамгийн их ус ашигладаг Топ 10 ААН, Усаар хангагч байгууллагын Топ 10 ААН, 2020-2024 оны ус ашиглалтын мэдээг салбараар гарган shilen.gov.mn-д байршуулсан.	100%
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт							
14	Үүрэг даалгавар1. “Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж удалдан авах” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах.	Хуулийн хүрээнд зохион байгуулах	-	Шаардлагад нийцсэн бараа, бүтээгдэхүүн, программыг судалгааны багт хүлээлгэн өгнө.	“Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах” ажлын зохион байгуулах.	Усны газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/76 дугаар тушаалаар “Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж удалдан авах” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Уг үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг www.tender.gov.mn цахим системд 2025.05.30-ны өдөр байршуулж, тендерийг хүлээн авч байна. Тендерийн нээлтийг 2025.06.23-ны өдөр хийнэ.	90%


15	<p>Үүрэг даалгавар 2. Усны нөөцийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах.</p>		<p>Зөвлөлийн хуралдааны тоо</p>	2	<p>Усны нөөцийн зөвлөлийн хуралдааны 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.</p>	<p>Усны нөөцийн зөвлөлийн 2025 оны 4-р хуралдаан 04 дүгээр сарын 18-нд зохион байгуулсан. Уг хурлаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Усны нөөцийн зөвлөлийн үйл ажиллагаа болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлуудыг танилцуулах; 2. "Хилийн усны хэлэлцээр"-ийн талаар танилцуулах; 3. "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн хүрээнд хийгдэх судалгааны ажлуудын ажлын даалгаварыг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцсэн. <p>УНЗ-ийн 5-р хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Уг хурлаар СГЗ-ын УННМ-ийн төлөвлөгөөг хэлэлцсэн. Гүйцэтгэл-100%</p>	100%	
ДӨРӨВ ДҮГЭЭР ХЭСЭГ. МЭДЛЭГ, МЭРГЭЖИЛ, МЭРГЭШИЛ, УР ЧАДВАР ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫН БИЕЛЭЛТ								
15	<p>Арга хэмжээ 4.1. Мэдлэг, мэргэжил, мэргэшил, ур чадвар дээшлүүлэх</p>	-	<p>Сургалтын тоо</p>	Гэрчилгээ-2	<p>Мэдлэг чадварыг дээшлүүлэх 3-аас доошгүй сургалтад хамрагдаж 2 –оос доошгүй гэрчилгээ авах</p>	<p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа сургалтанд хамрагдсан.</p>	100%	
16	<p>Арга хэмжээ 4.2. Агентлаг болон холбогдох төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохиогдсон сургалт, семинарт оролцох</p>	-	<p>Сургалтын тоо</p>	5	<p>Сургалт, семинарт хамрагдах тоо-5</p>	<ul style="list-style-type: none"> • Удирдлагын академийн Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-д 2025 оны 01-р сарын 28-ны өдрөөс 2025 оны 05-р сарын 15-ны өдөр хүртэл суралцаж, сертификат авсан. • Төрийн зарим байгууллагуудад Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах СУРГАГЧ БАГШ-иар суралцаж сертификат авсан. • Усны нөөцийг хамгаалах, хуримтлуулах, нөхөн сэргээх, хяналт мониторинг хийх асуудлаар ХААИС-ын багш докторууд Хатантуулд мэдээлэл, хэлэлцүүлэг хийхэд оролцсон. 2025.01.22 • Улсын усны infowater.mn мэдээллийн санг бүрдүүлэх цахим сургалтаар мэдээлэл хэрхэн оруулах ажлыг аймаг нийслэлийн 	100%	

						<p>Байгаль орчны газруудад танилцуулахад оролцсон. 2025.02.07</p> <ul style="list-style-type: none"> • Экологийн цагдаагийн албанаас Экологийн байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хуулийн тухай сургалтанд хамрагдсан. 2025.02.06 • Удирдлагын академийн Монгол бичгийн мэдлэг олгох онлайн сургалтад давтан хамрагдан анхан шатны сертификатыг дахин авсан. 	
--	--	--	--	--	--	--	--

Төлөвлөгөөг үнэлсэн: Төсвийн шууд захирагч
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Тайлагнасан:
УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




З.БАТБАЯР

.....
Д.САЙХАНЖАРГАЛ

.....
Х.МЯГМАРЖАВ



**УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.МЯГМАРЖАВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**
(Удирдах албан тушаалтан буюу нэгжийн дарга)

Байгууллагын нэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар
Нэгжийн нэр: Ус ашиглалтын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	95.0	65.6

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.Мэдлэг, мэргэшил, ур чадвараа дээшлүүлэх	100.0	15.0
2.	Арга хэмжээ 2.Агентлаг болон холбогдох төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохиогдсон сургалт, семинарт оролцох	100.0	15.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15.0

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	-
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	-
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	-
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.)	65.6
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15.0
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-

Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	95.6
---	-------------

Үнэлгээ өгсөн: Төсвийн шүүмэл зөвлөл
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ГҮРЛӨГЧИЙГ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. БАТБАЯР /

2025 оны 06 сарын 19

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: Нэгжийн дарга
УСНЫ АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ГҮРЛӨГЧИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х. Мянмаржав / Х. МЯГМАРЖАВ /

2025 оны 06 сарын 22..